

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 4/26

Өлгий

Г Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны “Халдварт өвчний сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай” 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам, заавар шинэчлэн батлах тухай” 328 дугаар тушаал, 2018 оны А/528 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 6 сарын аяны удирдамж, төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагаанд зарцуулах зардлын тооцооллыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйл ажиллагааг эрчимжүүлэн зохион байгуулж, тайлагнахыг харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Аяны хугацаанд хэрэгжүүлсэн ажлын тайланг сар бүрийн 25-ны дотор ирүүлсүгэй.

4. Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтийн тайланг нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулахыг Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн /А.Нургүл /-д үүрэг болгосугай.

5. Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх талаар ард иргэдэд өргөнөөр сурталчлахыг А.Нургүл, Т.Рахат нарт үүрэг болгосугай.

6. Сургалт зохион байгуулах, сурталчилгааны үйл ажиллагааны зардлыг хөтөлбөрийн дотоод урсгалын санхүүжилтээс гаргахыг Эрүүл мэндийн газрын ня-бо /Х.Лена/-д зөвшөөрсүгэй.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /Е.Сауле/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.САКЕН



Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 сарын 10 өдрийн 1/26 тоот
тушаалын ... хавсралт



ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ 6 САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. ҮНДЭСЛЭЛ

Манай аймгийн хэмжээнд 2022 оны эхний 3 сарын байдлаар халдварт өвчний нийт 2043 тохиолдол буюу 10000 хүн амд 188.5 тохиолдол бүртгэгдсэн нь улсын дундажтай харьцуулахад бага үзүүлэлттэй байна. Гэдэсний халдварт өвчнийг сүүлийн 5 жилээр авч үзэхэд 2017 онд 22, 2018 онд 99, 2019 онд 155, 2020 онд 49, 2021 онд 21 тохиолдол тус тус бүртгэгдсэн ба халдварт өвчний дотор 71,3%-ийг гепатитын вирусийн цочмог халдвар, 23.4%-ийг хоолны хордлого эзэлж байна.

Урин дулааны улиралд аялал зугаалга, хөдөө, хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн ихэсдэг, мөн гудамж, талбайд ил задгай хүнсний бүтээгдэхүүнийг ихээр худалдаалдагтай холбоотой хоол хүнсээр дамжих халдварын эрсдэл эрс нэмэгддэг тул гэдэсний халдварт өвчин гарах эрсдэл их болдог. Гэдэсний халдварт өвчинд цусан суулга, сальмонеллез, Е коли буюу гэдэсний савханцрын халдвар, энтеровирусын халдвар, гепатит А буюу халдварт шар зэрэг өвчин багтана. Гэдэсний халдварт өвчний онцлог нь өндөр хоруу чанартай цөөн тооны бичил биетэн (нян, вирус) хүний биед орсон тохиолдолд өвчлүүлэх боломжтой бөгөөд эдгээр өвчин үүсгэгч нян вирус нь халдварт өвчтэй хүн, мал амьтнаас гадна орчинд халдварлан улмаар хоол хүнсний зүйл, бохир гар, ус, хөрс, эд зүйлсээр дамжин хүний биед халдварлаж өвчин үүсгэнэ. Хамгийн энгийн арга бол Гарын ариун цэврийг сахиж, гараа савантай усаар угаах явдал юм. Гэдэсний халдварт өвчнөөр өвдөх эрсдэлийг гарын ариун цэвэр сахиснаар 50% хүртэл бууруулах боломжтой гэдгийг судалгаагаар тогтоосон байдаг.

Бохирлогдсон хүнсний бүтээгдэхүүн, мах, сүү, ногоо, жимснээс халдвар дамжиж болох бөгөөд хоол хүнс өвчин үүсгэгч нян, вирусээр бохирдоход нөлөөлөх гол хүчин зүйл нь хоол хүнсийг боловсруулах, зөөвөрлөх, хадгалах, хэрэглэх үеийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага алдагдах явдал юм.

Хоёр. ЗОРИЛГО: Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх

Гурав. ЗОРИЛТ:

Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдварын сэжигтэй тохиолдол болон хавьталыг эрт илрүүлэх, өвчтөнийг тусгаарлах, голомтын хариу арга хэмжээг авах

Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 6 сарын аяныг зохион байгуулах

Хүн амын дунд өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалт зохион байгуулах

Дөрөв. ХАМРАХ ХҮРЭЭ: Ард иргэд, асран хамгаалагчид, хүүхдүүд, эмнэлгийн ажилчид

Тав. ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: Харьяа эрүүл мэндийн байгууллагы

Зургаа. ХУГАЦАА: 2022.05.06-2022.10.06-ны хүртэлх хугацаанд

Долоо. ХҮРЭХ ҮР ДҮН:

Гэдэсний халдвараас урьдчилан сэргийлэх, халдварыг эрт илрүүлэх, хүн амын дундах вирусын халдварын тархалтыг хязгаарлах, өвчлөл, нас баралтыг бууруулна.

Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын тандалтыг өргөжүүлэх замаар хариу арга хэмжээний бэлэн байдлыг ханган орчны бохирдолтой холбоотой халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх, тандах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүн ам, эрсдэлт бүлгийн дунд гэдэсний халдварын талаар болон эрсдэлт зан үйлийг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулах, чанаржуулах, мэргэжилтнүүдийг давтан сургана.

Хоолны хордлогот халдварын тандалт, хариу арга хэмжээг зохион байгуулахад эрүүл мэндээс бусад салбарын байгууллагатай хамтран ажиллана.

Хоол, хүнс, усаар дамжих халдварын тархалтад нөлөөлөх эрсдэлийг бууруулах, хүүхдийн байгууллагад ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг мөрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдварт өвчний өвчний тоо буурна.

ХЯНАСАН: НЭМХ-ИЙН ДАРГА



Е. САУЛЕ

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ЭМГ-ЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



А. НУРГУЛ

**ГЭДЭСНИЙ ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022.05.06

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот өвчнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх	2022.05.06-12-ны хүртэл	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
2	Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх өдөрлөг зохион байгуулах, гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх талаар гарын авлага тараах	2022.05.12	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
3	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох Дербес ТВ, Саян ТВ, орон нутгийн радиогоор Гэдэсний халдварт өвчин, халдварт шар өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөөг 7 хоног бүр 3-оос доошгүй нэвтрүүлэх	2022 оны жилийн турш	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
4	Аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, арга зүйч, эмч, нийгмийн ажилтан нарт гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, мэргэжлийн арга зүйгээр хангах, зөвлөмж хүргүүлэх	2022 оны жилийн турш	Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
5	Ариутгал, халдваргүйтгэлийн бодисын зааварчилгааны талаарх харьяа эрүүл мэндийн төвүүд болон сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөмж хүргэх	2022.05 сард	Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар
6	Аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, арга зүйч, эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан нарт гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, мэргэжлийн арга зүйгээр хангах	2022.05.06-2022.10.06	Эрүүл мэндийн газар, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд

7	Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх, гар угаах гарын авлага бэлдэж, сургууль, цэцэрлэгүүдэд тараах	2022.05.06- 2022.10.06	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
8	Сургууль, цэцэрлэгүүдэд гар угаах нөхцөл боломжийг бүрдүүлсэн эсэх,гал тогоонд ариун цэврийн дүрмийн шаардлагыг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажилласан эсэхэд хяналт тавих	2022.05.06- 2022.10.06	Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
9	Бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний тохиолдол бүрийн тархвар зүйн судалгааг нарийвчлан гаргах	2022 оны жилийн турш	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд
10	Үйл ажиллагааны явцын тайланг сар бүрийн 25-ны дотор хугацаанд nurgulasilbek8@gmail.com мэйл хаягаар баримтжуулалттай хамт ирүүлэх	Сар бүр	Нэгдсэн эмнэлэг, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд

ХЯНАСАН:ЭМГ-ЫН НЭМХ-ИЙН ДАРГА

 Е. САУЛЕ

БОЛОВСРУУЛСАН:ЭМГ-ЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 А. НУРГУЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 сарын 10 өдрийн 1/26 тоот
тушаалын хавсралт

ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВИЙН ЗАРДАЛЫН ТООЦООЛОЛ

№	Зардлын төрөл	Тоо, ширхэг	Нэгж үнэ /мян. төг/	Нийт /мян. төг/
1	Анонус хэвлүүлэх	1ш /3х2/	100 000	100.000
2	Гарын авлага хэвлүүлэх	300 ш	1000	300.000
3	Сургалтын үйл ажиллагааны хэрэгсэл	Санитол -1 ш	10000	10 000
		Сальфетки - 1 ш	10000	10 000
Нийт				420 000

ХЯНАСАН:ЭМГ-ЫН НЯ-БО
ТООЦООЛОЛ ГАРГАСАН: ЭМГ-ЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Х. ЛЕНА

А. НУРГУЛ